

# ХИЧЭЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Хичээлийн нэр: Хотын ложистик  
Urban logistic

Хичээлийн индекс: ENEN 301  
Хичээлийн ангилал: Бакалавр  
Хичээлийн төрөл: Мэргэжлийн хичээл  
Хичээлийн багц цаг: 3 ББц  
лекц 2 Бц  
семинар 1 Бц  
лаборатори 0 Бц


Судлах улирал: Бүх улирал

Нийт хуудасны тоо: 6

Цахим хичээл: Бүрэн цахим хичээл

<https://online.num.edu.mn/courses/course-v1:NUM+ENEN301+2022/course/>

## Боловсруулсан:

Бүрэлдэхүүн сургууль	Тэнхим	Багшийн нэр, цол, зэрэг	Гарын үсэг
ХШУИС	Хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн тэнхим	Ахлах багш, доктор Б.Энхчимэг	

## Зөвшөөрсөн:

Бүрэлдэхүүн сургууль/ тэнхимийн хөтөлбөрийн дэд хорооны нэр	Хэлэлцүүлж зөвшөөрсөн хурлын огноо	Хөтөлбөрийн дэд хорооны даргын нэр, цол, зэрэг	Гарын үсэг
ХБООИ-ийн тэнхимийн хөтөлбөрийн дэд хороо		Хөтөлбөрийн дэд хорооны дарга, профессор Ч.Сономдагва	
ХШУИС-ийн хөтөлбөрийн дэд хороо		Хөтөлбөрийн дэд хорооны дарга, профессор Н.Баатарбилэг	

## Баталсан:

Хичээлийн хөтөлбөрийг МУИС-ийн ХШУИС-ийн Хөтөлбөрийн дэд хорооны 2022 оны ... –р сарын ... -ны өдрийн хурлаар хэлэлцэж батлав.

Тамга



Co-funded by the  
Erasmus+ Programme  
of the European Union



Urban Resilience and Adaptation for India and Mongolia:  
curricula, capacity, ICT and stakeholder collaboration to support green & blue infrastructure and nature-based solutions  
619050-EPP-1-2020-1-DE-EPPKA2-CBHE-JP

## Хичээл заах багш нарын мэдээлэл:

---

Тэнхимийн нэр: Хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн тэнхим  
Багшийн нэр, цол зэрэг: Ахлах багш, доктор Б.Энхчимэг  
Утас: 99163958  
Цахим шуудан: [enkhchimeg.b@num.edu.mn](mailto:enkhchimeg.b@num.edu.mn)  
Өрөө: 3-р байрны 230а  
Зөвлөгөө өгөх гараг, цаг: Өдөр бүр 09:00 – 18:00  
Цахим хуудас: <http://seas.num.edu.mn/>

---

Тэнхимийн нэр: Хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн тэнхим  
Багшийн нэр, цол зэрэг:  
Утас:  
Цахим шуудан:  
Өрөө:  
Зөвлөгөө өгөх гараг, цаг: Өдөр бүр 09:00 – 18:00  
Цахим хуудас: <http://seas.num.edu.mn/>

---

Энэ хичээлийн тодорхойлолтыг 2020 онд батлагдсан “МУИС-ийн цахим сургалтын түр журам”-ыг баримтлан боловсруулав.





Co-funded by the  
Erasmus+ Programme  
of the European Union



Urban Resilience and Adaptation for India and Mongolia:  
curricula, capacity, ICT and stakeholder collaboration to support green & blue infrastructure and nature-based solutions  
619050-EPP-1-2020-1-DE-EPPKA2-CBHE-JP

## ХИЧЭЭЛИЙН ЗАЛГАМЖ ХОЛБОО

Өмнө үзсэн байх хичээлийн нэр, индекс:

1. Хүрээлэн буй орчин судлал ENVI200
2. Хүрээлэн буй орчны инженерчлэл ENEN303

Зэрэгцүүлэн үзэхэд тохиромжтой хичээлийн нэр, индекс:

3. Цэвэр энергийн технологи ENEN304

## ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

Энэ хичээлийн зорилго нь оюутнуудад хотын тээвэр ложистикийн тухай суурь мэдлэгийг лекцийн хэлбэрээр олгох бөгөөд энэхүү салбарт тулгамдаж байгаа асуудлуудыг шийдэх чадваруудыг эзэмшүүлэх юм.

The aim of this course is to provide basic knowledge of urban logistics to students and to provide them with the ability to solve issues facing in this sector.

## ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

Энэхүү хичээл нь хотын тээвэр, ложистикийн үйл ажиллагаа болон менежементийн аргуудын талаар заана. Суралцагч нь тээвэрлэлтийн инженерчлэлийн суурь мэдлэгүүд болох тээвэрлэлтийн системийн үйл ажиллагаа, загварчлал, төлөвлөлт болон засварын тухай ойлголтуудыг хэрхэн аюулгүй, найдвартай, тохь тухтай нийгмийг бүтээхэд ашиглаж болох тухай мэдлэг олж авна. Түүнчлэн, энэхүү хичээлээр хүний эрүүл мэнд, эдийн засаг, хүрээлэн буй орчинд өнөөгийн хотын ложистикийн асуудлууд хэрхэн нөлөөлдөг тухай суурь мэдлэг олж авна. Өндөр хөгжсөн орнуудын хотуудын ложистикийн давуу тал болон тулгамдаж байгаа асуудлуудыг харьцуулан дүн шинжилгээ хийж, өөрийн оронд тулгарч байгаа тээвэр, ложистикийн асуудлуудыг шийдэх тохиромжтой санаа, шинэ шийдлүүдийг хэлэлцэж, анализ хийнэ.

This course covers different approaches to the management and operation of logistics and transportation in cities. At the end of the lecture, students will gain knowledge on transportation engineering that involves the operation, design, planning, and maintenance of transportation systems to help build safe, security and livable communities. Moreover, at the end of the course, students will obtain basic understanding of side effects in city logistics to urban economy, environment and human health. In addition, the course is to compare and analyze advantages and disadvantages of city logistics in national and international context. Finally, students will discuss a solution and their opinions for national issues in logistics based on the lecture materials and self-learning references.

## ХИЧЭЭЛЭЭР ЭЗЭМШИХ МЭДЛЭГ, ЧАДВАР, ДАДАЛ

Тус хичээлээр оюутнууд хотын тээвэр, ложистикийн талаар ерөнхий, суурь мэдлэгийг лекц хэлбэрээр олж авах бөгөөд өөрийн орны болон бусад орны ложистикийн давуу болон дутагдалтай талуудыг харьцуулж анализ хийснээр бодит, практик мэдлэг олж авна. Түүнчлэн, өгөгдсөн даалгаварын хүрээнд мэдээллийг хайх, хайсан мэдээллээ боловсруулж тайлан бичих, өгөгдлийг харьцуулж анализ хийх, өөрийн бодлоо илэрхийлэх, багаар ажиллах, илтгэл тавих гэх мэт ерөнхий чадваруудыг эзэмших болно.

## ЗААХ АРГА БАРИЛ

Энэхүү хичээл нь шавь төвт сургалтын арга барилд тулгуурлах ба лекц, харилцан яриа, семинар, багаар ажиллах, бие даалт гүйцэтгэх, төсөл тайлан бичилт, судалгаа гүйцэтгэх, мэдээ цуглуулах, түүнд анализ хийх, илтгэл тавих гэх мэт олон хэлбэрээр явагдана.



## ХИЧЭЭЛИЙН ДААЛГАВАР

Энэхүү хичээл дээр 2 оюутан нэг баг болж хичээлийн лекцийн дагуу семинарын хичээл дээр кэйс судалгаа болон хүрээлэн буй орчны тооцоо судалгааг хийж багаараа ажиллаж, баг бүр 10 минутын илтгэл семинар бүр дээр хэлэлцүүлнэ.

## ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ (ирц, явц, шалгалт)

Дараах хэлбэрүүдээр суралцагчдын мэдлэг, ур чадварыг үнэлнэ. Үүнд:

1. Ирц, идэвх
2. Явцын шалгалт
3. Бие даалт
4. Улирлын шалгалт

Дүгнэх зүйл	Оноо	Тайлбар
Ирц	20	Цахим хичээлд хандалтаар үнэлнэ
Идэвх	30	Семинарын хичээлд оролцох оролцоогоор үнэлнэ.
Явцын шалгалт	25	Үзсэн хичээлийнхээ дагуу тестийн шалгалт авна
Улирлын шалгалт	25	Багаар бие даалтын ажил гүйцэтгэж, илтгэл тавина
Нийт	100	

## ХИЧЭЭЛД АШИГЛАХ НОМ, СУРАХ БИЧГИЙН ЖАГСААЛТ

1. Б.Батчимэг, (2018) “Логистик ба нийлүүлэлтийн хэлхээний менежемент”, Мөнхийн үсэг ХХК, Улаанбаатар, Хуудас 72, Монгол хэл
2. Meyer, Michael, and Eric Miller. *Urban Transportation Planning*. New York, NY: McGraw-Hill, 2001. ISBN: 9780072423327. The ISBN for the paperback version of the textbook is 9780071200004.
3. François-Joseph Van Audenhove, Sam De Jongh, and Marc Durance. “*Urban Logistics*”. , Arthur D. Little, Paris  
[https://www.adlittle.com/sites/default/files/viewpoints/ADL\\_Urban\\_Logistics.pdf](https://www.adlittle.com/sites/default/files/viewpoints/ADL_Urban_Logistics.pdf)
4. Б.Батчимэг, (2020) “Дотоод болон Олон Улсын худалдаанд ашиглагдах ОУХТ-ын дүрэм”, редакторууд Ш.Цэвэлсайхан, Улаанбаатар, хуудас 200, ISBN:978-92-842-0510-3, Монгол хэл

## ХИЧЭЭЛИЙН СЭДЭВЧИЛСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Лекцийн хичээл:

7 хоног	Хичээлийн сэдэв	Сэдвийн агуулга	Цаг
1	Удиртгал хичээл	Хотын ложистик гэж юу вэ? Суурь ойлголтууд	2
2	Нийлүүлэлтийн гинжин хэлхээ	Хотын ачаа тээврийг системийн хандлагыг ашиглан хэрхэн ойлгож, үнэлж, сайжруулах	2
3	Нийлүүлэлтийн сүлжээний менежемент ба хотын ложистикийн хоорондох үзэл баримтлалын ялгаа	Хотын ложистикийн гол хөдөлгөгч хүчин зүйлүүд, Ложистикийн гинжин хэлхээ	2
4	Тээвэрлэлт болон байгууллагын худалдан авалтын зан төлөв	Эх сурвалжийн найдвартай байдал Тээвэрлэлт болон байгууллагын худалдан авалтын зан төлөв Үйлдвэрлэлийн ложистик-яг цагт нь систем	2
5	Худалдан авалтын үйл ажиллагаа	Худалдан авалтын үйл ажиллагаа болон Худалдан авалтын загварууд	2

6	Монгол Улсын тээвэр, ложистикийн салбарын дүн шинжилгээний арга зүй	Монгол Улсын тээвэр, ложистикийн салбарын онцлог болон бүсийн ложистизийн төвүүд	2
7	Хотын ложистикийн орон зайн болон функциональ бүтэц	Дэлхийн хотуудын хотын ложистик, хотын ложистикийг төлөөлдөг таван ангилал	2
Явцын шалгалт		Дээрх сэдвүүдийг хамарсан явцын тестийн шалгалт	
8	Улаанбаатар хотын хүрээлэн буй орчин	Агаарын болон дуу чимээний бохирдлын тухай	2
9	Хотуудын бараа хүргэхэд тулгарч буй бэрхшээл, боломжууд	Орон нутгийн түвшинд тодорхойлсон шийдлүүд: Зохицуулалт ба газар төлөвлөлт, Дэд бүтэц Санхүүгийн урамшуулалтээвэрээс үүдэлтэй гадны нөлөөллийг бууруулах, Тоног төхөөрөмж, технологи	2
10	Хотын ачаа тээвэр түгээх суваг	Хотын ачааны хуваарилалтын хоёрдмол байдал	2
11	Хотын ложистикийн сорилтууд	Түгжрэл, зогсоол, Газар ашиглалт, Ногоон ложистик, Цахим худалдаа, Дүрэм журам болон Хотын ложистикт хот төлөвлөлтийн стратеги үзүүлэх нөлөө	4
12			
13	Хот суурин газрын хүргэлтэд зориулагдсан автономит тээврийн хэрэгсэл	Дэд бүтцийн ашиглалт, Тээврийн хурд, Автоматжуулалтын түвшин, Хэмжээ ба даацын тухай	2
14	Хотод хүргэх тээврийн хэрэгслийн автоматжуулалтад тулгарч буй бэрхшээлүүд	Хотын ачаа тээврийн талаарх ойлголтоо гүнзгийрүүлэх, шийдлүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд ашигладаг түгээмэл хэрэглэгддэг аргууд	2
15	Гуравдагч талын ложистикийн үйлчилгээ үзүүлэгчид	Гуравдагч талын ложистикийн үйлчилгээ үзүүлэгчид а. Үүрэг ба чиг үүрэг, б. Ложистик үйлчилгээний систем в. Хотын ложистик дахь интеграцлал	2
16	Ложистикын хөгжил	МУ-ын нийгэм эдийн засгийн байдал болон худалдааны салбар	2
Улирлын шалгалт		Бие даалт	
<b>Нийт</b>			<b>32</b>

### Семинарын хичээл:

7 хоног	Хичээлийн сэдэв	Сэдвийн агуулга	Цаг
1	Хотын бараа бүтээгдэхүүний импорт, экспортын хэрэгцээ, шаардлага	Хамгийн их экспортлодог, импортлодог бараа бүтээгдэхүүнийг олж хаанаас яаж хэрхэн тээвэрлэдэг мөн тээвэрлэлтийн төрлүүдийн хүчин чадал	2
2	Хотын бараа бүтээгдэхүүний импорт, экспортын хэрэгцээ, шаардлага, тээврийн зардлын тооцоо	тухайн сонгосон улс орныхоо тээвэрлэлтийн төрлүүд дээр үндэслэн шатхууны төрөл, зардал тооцоог гаргах	2
3	Монгол орны импорт, экспортын хэрэгцээ, шаардлага, тэдгээрийн тээврийн зардлын тооцоо	Монгол орны экспорт, импортын бараа бүтээгдэхүүн, тэдгээрийн тээвэрлэлтийн төрлүүд дээр үндэслэн шатхууны төрөл, зардал тооцоог гаргаж ирэх	2
4	Монголын үндэсний үйлдвэрлэгчдийн ложистикт үзүүлэх нөлөө	Монголын үндэсний үйлдвэрлэгчээс нэг байгууллага сонгож аван тухайн бүтээгдэхүүний түүхий эдээс эцсийн бүтээгдэхүүн хүртлэх шат дамжлага	2
5	Тээвэрлэлтийн зардлын тооцоо	Эхний тээвэрлэлтээс эцсийн бүтээгдэхүүний хүртлэх шат дамжлага тээварлэлтийн хугацаанд нийт зарцуулах км, бензин тооцоо	2

6	Ухаалаг системийг хэрэгжүүлэх боломж	УБ хотод хэрэгжүүлэх боломжтой замын ямар ямар ухаалаг систем хэрхэн яаж нэвтрүүлэх боломжтой вэ? Тухайн системийнхээ талаарх бусад орны жишээг, үр дүнг мөн танилцуулсан илтгэл	2
7	Хотын ложистикын индексийн тооцоолол, харьцуулсан судалгаа	LPI-д хамгийн эхэнд жагсдаг 10 орны улс хоорондын харьцуулалтыг хийх.	2
8	Монгол Улсын ложистикын үзүүлэлт	LPI-ын стандарт статистикийн аргуудыг ашиглан Монгол Улсын ложистикын үзүүлэлтийг сүүлийн 10 жилийг хооронд нь харьцуулсан судалгаа хийх	2
9	Хотуудын бараа хүргэхэд тулгарч буй бэрхшээл, боломжууд	Орон нутгийн түвшинд тодорхойлох үндсэн ангилалыг ашиглан МУ-ын ложистикийн хувьд одоогийн нөхцөл байдлын талаар анализ хийх	2
10	Жижиглэнгийн худалдаа, түүний хотын ложистикт үзүүлэх нөлөөлөл	Эхний цэгээс эцсийн цэг хүртлэх тухайн барааны зайг тооцоолох	2
11	УБ хотын түгжрэл, түүнийг бууруулахад жижиглэнгийн худалдааны оролцоо	УБ хотын тээвэрлэлтийн хэдэн хувийг жижиглэнгийн худалдаа эзэлдэг, түүний бууруулах сайжуулах арга зам болон гадны туршлагуудын жишээ оролцуулах	2
12	УБ хотын түгжрэл, түүнийг бууруулахад томоохон үйлдвэрүүдийн оролцоо	Тээвэрлэлтийн явах зайг бууруулах сайжуулах арга зам болон гадны туршлагуудын жишээ оролцуулах	2
13	Хот суурин газрын хүргэлтэд зориулагдсан автономит тээврийн хэрэгсэл, түүнийг нэвтрүүлэх боломж	УБ хотын худалдааны салбарт автоматжуулалтын аль загвар аль салбарт илүү нийцтэй байх талаар судалгаа хийх	2
14	Хотод хүргэх тээврийн хэрэгслийн автоматжуулалтад тулгарч буй бэрхшээлүүд	УБ хотод тээврийн хэрэгслийн автоматжуулалтад тулгарч буй бэрхшээлүүдийн талаарх мэдээлэл тооцоо судалгааг хийх.	2
15	Монгол Улсын ложистикийн хууль эрх зүйн орчин	Монгол Улсын тээвэр ложистикийн хууль эрх зүйн орчинг судлах	2
16	Монгол Улсын ложистикийн хууль эрх зүйн орчинг сайжруулах арга зам	Монгол Улсын тээвэр ложистикийн хууль эрх зүйн орчны дутагдалтай тал, түүнийг сайжруулах, бусад улс орны хэрэгжүүлсэн амжилттай туршлагууд дээр үндэслэн сайжруулалт хийх	2
<b>Идэвх</b>		<b>Илтгэсэн байдал</b>	
<b>Нийт</b>			<b>32</b>